



MONGOLIAN
NATIONAL
FILM COUNCIL



КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНГААС 2022 ОНД

САНХҮҮЖИЛТ ОЛГОСОН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

№	“Алдагдсан өдрүүд” хүүхдийн кино төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	Баянжаргал ГАРАМХАНД
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	<ul style="list-style-type: none"> • Дуу, дүрсний найруулгын үе шат • Кино түгээлтийн бэлтгэл ажил

“Алдагдсан өдрүүд” уран сайхны кино нь төлөвлөсөн хугацааны дагуу хийгдэн 2023 оны 05-р сарын 26 ны өдөр Улаанбаатар хотын бүх кино театруудаар түгээгдэж эхэлсэн.



“АЛДАГДСАН ӨДРҮҮД” уран сайхны киноны амжилт:

“УЛААНБААТАР” олон улсын XV дугаар кино наадмын “Монгол киноны уралдаант хэсэг”-т шалгарч “ШИЛДЭГ ХӨГЖМИЙН НАЙРУУЛГА” шагнал хүртсэн.

№	“Алтан өргөө” кино наадам зохион байгуулах төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	“Жигжидсүрэн монголын кино институт” Холбоо /НҮТББ/
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	<ul style="list-style-type: none"> • Кино бэлтгэл наадмын ажлыг хангах • Олон улсын кино наадам зохион байгуулах



“Алтан өргөө” олон улсын кино наадам зохион байгуулах төсөл нь Кино урлагийн зөвлөлтэй гэрээлсэн хугацаанд төслийн хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 07-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан.

“Алтан өргөө” олон улсын кино наадмын хүрээнд дараах тооны хөтөлбөрүүд болон үзвэрүүдийг багтаав.

- 6 Богино хэмжээний хөтөлбөрүүд
- 8 Бүрэн хэмжээний кино үзвэрүүд
- Ретроспективын 4 бүрэн хэмжээний кино үзвэр
- 11 Монгол уралдаант хэсгийн богино кино
- 14 олон улсын уралдаант хэсгийн богино кино
- 1 хэлэлцүүлэг
- 1 сургалт
- 1 мастер класс

Алтан Өргөө кино наадмын хүрээнд АНУ-ын элчин сайдын яам, American Film Showcase, Монголын кино институт, Lotus Pictures, мөн Монголын кино урлагийн зөвлөл хамтран Америкийн продюсер Аликс Мадиган-Йоркийн 3 өдрийн Инди киноны продюсерын сургалтыг 6 сарын 8, 10, 11-нд зохиов.

Аликс 2010 онд “Өвлийн эрэл” киноны продюсероор ажиллаж Сандэнс кино наадмын Шүүгчдийн дээд шагналын эзэн болж байв. Уг кино нь мөн Оскарын дөрвөн төрөлд нэр дэвшсэний дотор Шилдэг дэлгэцийн бүтээл төрөл багтана. Аликс Film Independent-ийн удирдах зөвлөлд багтдаг бөгөөд AMPAS (Америкийн кино урлагийн академи)-ийн гишүүн юм.

Бүртгүүлсэн хүмүүсээс Аликс Мадиган сонгож сургалтыг дээр дурдсан өдрүүдэд ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ орсон болно. Нийт 55 хүн бүртгэлээ ирүүлснээс 20 хүнийг Аликс Мадиган сонгон сургалтад хамруулсан. Аликс Мадиган үг сургалтаар өөрийн продюсерын арга барил, туршлагаас харамгүй хуваалцсан байна.

№	“Кино нүүдэл” сургалт зохион байгуулах төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	“Иргэдийн цахим оролцоо” Холбоо /НҮТББ/
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	<ul style="list-style-type: none"> • Сургалтын бэлтгэл ажлыг хангах • Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах



2023 оны 08 дугаар сарын 01-ээс 09 дүгээр сарын 29-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан. Тус сургалтын хүрээнд 100 уран бүтээлч хамрагдсан. “Кино нүүдэл” олон улсын сургалтын онлайн хөтөлбөрт хамрагдсан уран бүтээлчдэд (КИНО ЗОХИОЛ БИЧИХ СУРГАЛТ – 53 уран бүтээлч, КИНО ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ – 47 уран бүтээлч) 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр батламж гардуулсан.

“Киноны нүүдэл” олон улсын сургалтын хүрээнд дараах арга хэмжээнүүд зохион байгуулагдсан байна. Үүнд:

- Кино зохиол бичих танхимын сургалт
2023 оны 9-р сарын 4-8
- Кино төсөл боловсруулах танхимын сургалт
2023 оны 9-р сарын 11-15
- Кино Форум
2023 оны 9-р сарын 25-26
- Кино төсөл танилцуулга-Pitching
2023 оны 9-р сарын 28-29

Кино танилцуулгад оролцсон олон улсын продюсер, сангийн төлөөллийн шүүлтээр



- Д. Удвалын "Тахал" уран сайхны кино төсөл,
- Н. Анхбаяр "Жагаа, жолооч хоёр",
- Ш. Ихбаярын "Аяга Арц" уран сайхны кино төсөл шалгарч цаашид салбарын мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр цаашид хөгжих бололцоотой боллоо. Эдгээр гурван төсөл нь Улрик Болт, Эстер Кэнхилл, Дайан Тейлор нартай хамтран ажиллаж төслийн зохиол, төслийн хөгжүүлэлтийг сайжруулж, олон улсын лаборатори, ижил төстэй хөтөлбөрүүдэд бэлтгэх юм.

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНГААС 2022 ОНД САНХҮҮЖИЛТ ОЛГОХООР ШАЛГАРСАН ТӨСЛҮҮД

“НАРУМИ” киноны нүүр хувиргалтын эрчимжүүлсэн сургалт зохион байгуулах төслийн хэрэгжилт

№	“Наруми” сургалт зохион байгуулах төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	“Нарумимэйк ап” ХХК
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	<ul style="list-style-type: none"> • Сургалтын бэлтгэл ажлыг хангах • Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах

2023 оны 09 дүгээр сарын 04-өөс 10 дугаар сарын 04-ны хооронд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж 15 суралцагч Киноны мэргэжлийн нүүр хувиргалтын сертификат гардан авсан.



№	“Өмнөдийг зорих замд” баримтат кино төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	“Хүлэгү пикчерс” ХХК
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	Кино зураг авалтын үе шат

“Өмнөдийг зорих замд” уран сайхны киноны зураг авалтыг 2023 оны 8 - 9 саруудад Өмнөговь аймгийн Ноён сум, Цайлангийн заставт Монгол, Солонгос хоёр орны уран бүтээлчдийн багт хамтран гүйцэтгэсэн. Хилийн орчмын зураг авалтыг монгол уран бүтээлчдийн баг 2023 оны 9 дүгээр сард хийж гүйцэтгэж дуусгасан. Тус зураг авалтын баг нийт 100 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж 2023 оны 10 дугаар сард хээрийн зураг авалтаа дуусгасан. “Өмнөдийг зорих замд” уран сайхны киноны дуу, дүрсний найруулгын ажлууд Өмнөд Солонгос улсад хийгдэж буй бөгөөд 2024 онд Монгол, Солонгос хоёр оронд нээлтээ хийнэ.



№	“Солонго” кино төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	Энэбиш ГАН-ОЧИР
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	<ul style="list-style-type: none"> • Кино зураг авалтын үе шат • Дуу, дүрсний найруулгын үе шат

Киноны зураг авалт 2023.05-06 саруудад Өвөрхангай аймгийн Арвайхээр хот, Дулаанхайрхан сумдад хийгдэж монгол улсад дуу, дүрсний найруулгын ажлууд хийгдсэн ба нийт 14 удаагийн зураг авалтаар 30 гаруй цагийн бичлэг хийж гүйцэтгэсэн.



Киноны дуу, дүрсний найруулгын үе шатанд зургийн эвлүүлэг, дууны найруулга, өнгө шүүлт, постер бэлтгэх ажлууд хийгдэж дууссан бөгөөд 2024 онд “Солонго” баримтат кино нээлтээ хийхээр товлогдсон байна.



MONGOLIAN FILM DAY

IN CONJUNCTION WITH THE 74. BERLINALE - EUROPEAN FILM MARKET



CITY OF WIND (SER SER SALHI)

A film by Lkhagvadulam Purev-Ochir

№	“Сэр сэр салхи” кино төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	“Гурумедиа” ХХК
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	<ul style="list-style-type: none"> • Кино зураг авалтын үе шат • Кино түгээлтийн бэлтгэл үе шат


Киноны түгээлтийн мэдээлэл:

- Монгол улс /2023. 10 сараас/
- Франц /2024.04 сараас/
- Хонконг /2024.06 сараас/

80 дахь удаагийн “Венецийн олон улсын кино наадам”-аар олон улсад нээлтээ, “УЛААНБААТАР” олон улсын XV дугаар кино наадмын “НЭЭЛТИЙН КИНО”-оор шалгарч Монгол улс дахь нээлтээ тус тус хийсэн.



Олон улсын кино наадмуудад “Сэр сэр салхи” киноны үзүүлсэн амжилт:

- “УЛААНБААТАР” олон улсын XV дугаар кино наадмын “НЭЭЛТИЙН КИНО”- оор “СЭР СЭР САЛХИ” уран сайхны кино шалгарсан
- Венецийн олон улсын кино наадмын “Оризонти” хэсгийн Шилдэг эрэгтэй жүжигчний шагнал
- 28 дахь удаагийн “Бусаны олон улсын кино наадамд “ A Window On Asian Cinema хэсэгт шалгарсан
- Pingyao International Хятадын кино наадмын “Шилдэг найруулагч” шагнал
- Хонконгийн наадмаас Залуу шүүгчдийн шагнал
- 19 дэх удаагийн Осакагын Азийн Олон Улсын наадмын “Шилдэг кино”, “Шилдэг шинэ авьяас” шагнал
- 96 дахь удаагийн Оскарын наадамд Монгол улсыг төлөөлөн оролцох киногоор тодорлоо
- Torino Film Lab 2019, Torino Production Lab
- CNC Special Mention Award at Torino Film Lab
- Open Door Hub, Locarno IFF 2020&Production grant award
- Hubert Bals Fund Development Grant
- CNC International Co-Production Grant




№	“Хөг-жим тээгч” баримтат кино төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	Нямсайхан ТЭМҮҮЛЭН
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	<ul style="list-style-type: none"> • Кино зураг авалтын үе шат • Дуу, дүрсний найруулгын үе шат

“Хөг-жим тээгч” баримтат кино нь 2023 оны 12 сарын 24-нд нээлтээ хийсэн. киноны зураг авалт 2023.07 сард Улаанбаатар хот, Ховд аймаг, Баян-Өлгий аймаг, Алтай таван богд зэрэг байршлуудад хийгдэж, одоогийн байдлаар дуу, дүрсний найруулгын ажлууд Монгол улсад хийгдсэн.



№	“Цагаан хадны өнгө” баримтат кино төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	“Айсити” ХХК
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	<ul style="list-style-type: none"> • Кино зураг авалтын үе шат • Дуу, дүрсний найруулгын үе шат



Киноны зураг авалт 2023.07 - 08 сард Улаанбаатар хот Шивээ хүрээ боомт, Говь гурван сайхан, Гашуун сухайт боомт, Цагаан хадны суурьшлын бүс, Цогт цэций Таван толгойн орд зэрэг байршлуудад хийгдэж, Франц улсад дуу, дүрсний найруулгын ажлууд хийгдсэн. “Цагаан хадны өнгө” баримтат киноны хэсэг өгүүлэмжээр 25 минутын "Говийн бүсгүй" (Lady of the Gobi) богино хэмжээний кино бүтээж Английн Grierson Awards-ын “Шилдэг богино хэмжээний баримтат кино”-гоор тодорчээ.

